



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 10-өдөр

Дугаар А/297.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дасгал хөдөлгөөн хийцгээе” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аянг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. “Дасгал хөдөлгөөн хийцгээе” идэвхтэй хөдөлгөөн дэмжих аяныг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл удирдамжийн хүрээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, хэрэгжилтийн тайланг танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Т.Дэлгэрсайхан/, Биеийн тамир спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Түмэндэмбэрэл/, Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ